

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2019 оны 09 дүгээр сарын 13

Дархан-Уул аймаг

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах байгууллага	Хугацаа	Хэрэгжилтийн талаарх тэмдэглэл
1	2	3	4	5
1.	Брак байруудын дахин төлөвлөлтийн орон сууцад хамрагдах 1 айлтай гэрээ байгуулаагүй байгаа. Энэ 7 хоногт гэрээг байгуулж дуусгах	Хууль эрх зүйн хэлтэс	2019.09.15	16 айлтай гэрээ байгуулж, айл өрхүүдэд түлхүүрийг гардуулан өгч орон сууцандаа орсон.
2.	Архивын улсын үзлэг манай аймагт ирсэнтэй холбогдуулан Дархан сумын багийн Засаг дарга нарт анхааруулах, улсын үзлэгт бэлтгэх	Дархан сумын Засаг дарга	2019.09.15	9 дүгээр сарын 10-ны өдөр хамт олны хурал дээр багийн Засаг дарга нарт Архивын улсын үзлэгийн комисс багуудаар явж багийн Засаг даргын албан хэрэг хөтлөлтийг заавал үзэх тул байгууллагын албан хэрэг хөтлөлтийн стандарт, эмх цэгцийг хангаж улсын үзлэгт бэлтгэх тухай үүрэг чиглэл өгсөн.
3.	Захын урьд замын нүхэн гарц хийж байгаатай холбогдуулан хаагуур, аль замаар, хэрхэн явах талаар замын тэмдэг, тэмдэглэгээг хийх, чиглэл заасан зураг тавих	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	2019.09.15	"Туулын гүүр далай" ХХК-аас замын чиглэл заасан 2 самбар захиалсан бөгөөд 9 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар хэвлэлтээс гараагүй байна. Нүхэн гарц хийх ажлыг яаралтай дуусгаж 9 дүгээр сарын 19-ны өдөр замыг нээхээр төлөвлөн ажиллаж байна.
4.	Газрын төлбөрийг барагдуулах ажил график, төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа эсэхэд анхаарах, төлбөр барагдуулах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2019.09.15	Орон нутгийн 8 дугаар сарын орлогын мэдээнд газрын төлбөр тасарсантай холбогдуулан ГХБХБГ-т газрын төлбөрийн орлогыг биелүүлж ажиллах талаар албан тоот хүргүүлсэн.
5.	Тендер шалгаруулалтын сонгон ажилд анхаарах	Орон нутгийн өмчийн газар	2019.09.15	Хонгор сумын Хар бэлчирт 5 га газарт фермерийн аж ахуй эрхлэх аж ахуй нэгжийн сонгон шалгаруулалтын зарыг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн Өдрийн сонин, Darkhan.gov.mn сайт, ДУА-ийн ОНӨГ-ийн Facebook хуудсаар тус тус зарласан. 09 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл материалыг хүлээн авна.
6.	Өвс, хадлангийн ажилд анхаарах, халаалт, дулаан өгөх ажлын хүрээнд бэлэн байдлыг хангаж ажиллах, малын халдваргүйжүүлэх, тарилга болон өвөлжөөний ариутгал хийгдэж байгаа эсэх, 9 цэцэрлэгийн бохирын насосын засвар хийх зэрэг ажлуудад анхаарах	Орхон сумын Засаг дарга	2019.09.15	-Энхтал багийн ХХК-аас 1400 боодол өвс худалдан авахаар гэрээ байгуулсан. Өвс хадлан бэлтгэх ажлын хүрээнд 9 сарын 11, 12-ны өдрүүдэд ажлын хэсэг томилогдон Орхон сумын 100 гаруй малчин өрх, Хушаат, Ерөө, Бугант, Хүдэр зэрэг сумдуудаас өвс хадланг бэлтгэж байна. -9 дүгээр сарын 10-ны өдөр Орхон дэлгэр ХХК, Цагаан морьтой залуу

				<p>ХХК тус бүр усаа шахаж урьдчилсан байдлаар бэлэн байдлыг хангаж шалгаж үзсэн. Аливаа доголдол гараагүй. 9 дүгээр сарын 15-ны өдөр дулаан, халаалтаа өгөхөд бэлэн болсон.</p> <p>-Орхон сумын бүх малчин өрхийн мал аж ахуйд тарилга, туулга, угаалга хийгдэж дууссан. 9 дүгээр сарын 15-наас өвөлжөө болон зоорийн ариутгал хийхээр төлөвлөн ХХААГ болон Мал эмнэлгийн газарт тус бүр албан тоот хүргүүлээ.</p> <p>-Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийн бохирын насосын эвдрэлийг засварлах тухай хүсэлтийг ЗАА-д албан тоотоор хүргүүлсэн.</p>
7.	Халаалт, дулаан өгөх ажлын бэлтгэл хангах, засвар хийж байгаа гэрээ байгуулсан газруудын үйл ажиллагааг шалгах	Захирагчийн ажлын алба	2019.09.15	<p>Дархан сумын 1 дүгээр сургууль, Хонгор сумын Салхит багийн 11 дүгээр сургууль, Дархан сумын 12 дугаар цэцэрлэгийн гадна дулааны шугамын засварын ажилд хяналт тавьж ажиллаж байна. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд хийгдсэн ажлуудыг шалгаж сургууль, цэцэрлэгийн байгууллагуудаар НБХэлтэстэй хамтран шалгалт хийлээ. 9 дүгээр сарын 10-ны өдөр эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагуудтай уулзалт хийж 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн халаалт өгөх бэлэн байдлыг хангаж ажиллах талаар үүрэг чиглэл өгсөн.</p>
8.	Удирдлагууд бохир усны менежментийг сайжруулах төслийн нэгжийн хуралд суух	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Захирагчийн ажлын алба, Орон нутгийн өмчийн газар	2019.09.15	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй.
9.	НААҮГ-ийн ажилчид замын шороо шүүрдэж, тарьсан ногоо зүлэг рүү цацаж байна, өвөл нь цасаа овоолоод хаядаг. Энэ нь ажлын уялдаа холбоо байхгүй нэгнийхээ хийсэн ажлыг нөгөөх нь сүйтгэж байна. Үүнд анхаарах НААҮГ-т хогоо тусад нь авдаг машин өгсөн тэрийгээ яагаад хэрэгтэй үед нь хэрэглэхгүй байна.	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Захирагчийн ажлын алба	2019.09.15	Хотын хөдөлгөөн өглөө, оройны цэцэрлэг, сургууль, ажил эхлэх дуусах оргил цагуудад авто замын шороог шүүрдэн чирэгдэл үүсгэхгүй байх талаар НААҮГ-т үүрэг өгч, хяналт тавин ажиллаж байна. Мөн замын шороог авто замын хажуугийн хөвөө зурвас руу хийхгүй байх, зориулалтын хогийн саванд татан зайлуулах талаар зам талбайн 4 хэсэгт үүрэг өгсөн.
10.	Шарилж хөтөлбөрийн хүрээнд Дархан сумын ЗДТГ болон зарим аж ахуй	Дархан сумын Засаг дарга, Захирагчийн	2019.09.15	9 дүгээр сарын 10-ны өдөр хамт олны хурал дээр багийн Засаг дарга нарт Шарилж хөтөлбөрт ач

	нэгж байгууллага, зарим СӨХ-үүд маш муу ажилласан. Хийсэн ажлыг ямар ч үр дүнгүй болгож байна.	ажлын алба		холбогдол өгч СӨХ-үүд үүрэг даалгавар өгч үр дүнтэй ажиллах талаар үүрэг чиглэл өгсөн.
11.	Туслах аж ахуй эрхлэх санхүүжилтийг төсөт суулгасан байгаа, холбогдох захирамж, санхүүжилтийг хянаж үзээд татаж авах	Дархан сумын Засаг дарга, Орхон сумын Засаг дарга	2019.09.15	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй.
12.	Зоорийн давхрын ариутгал хийх. Дулаан өгөхөөр шугам сүлжээний засвар хийж ажил их гардаг зоорийн давхарт хүн орохын аргагүй нөхцөл байдалтай байдаг тул энэ ажлыг СӨХ-үүдэд анхааруулж ариутгалыг сайтар хийлгэх	Захирагчийн ажлын алба	2019.09.15	Дархан Дулааны Сүлжээ ТӨХК-аас ирүүлсэн орон сууцны зоорийн давхарт нохой бөөстэй байруудын жагсаалтын дагуу СӨХ-дын ажилд хяналт тавьж хороолол дотор газар дээр нь үзлэг хийж ажилласан.
13.	Багийн зохион байгуулагч нарын төсөл сонгон шалгаруулалтаар Хойд хаалганд "00" барих асуудлыг яаралтай дуусгах	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	2019.09.15	Иргэдийн оролцоотойгоор хийгдэж байгаа Хойд хаалган дээр 00 барих ажил 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр бүрэн хийж дуусгасан. "Дархан-хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГГазраас ажлын гүйцэтгэх 100% дууссан материалыг бэлтгэж ХОХБТХ-т комисс ажиллуулах тухай хүсэлтийг хүргүүлэхээр бэлтгэж байна.
14.	Их сургуулийн гудамжны зам дээр явган хүний гарц хийх ажлыг багийн Засаг дарга, ХОХБТХ хамтран хийх	Дархан сумын Засаг дарга	2019.09.15	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй. Ажил хийгдээгүй байна.
15.	Залуучууд театрын гаднах дэлгэцийг хүлээн авах, дэлгэцэнд орон нутгийн бүтээн байгуулалтын ажлыг сурталчлах	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Мэдээлэл технологийн алба	2019.09.15	"Дархан-хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГГазраас Залуучууд театрын дэлгэцийг шалгаж ажлын гүйцэтгэх 100% дууссан материалыг бэлтгэж ХОХБТХ-т комисс ажиллуулах тухай хүсэлтийг хүргүүлэхээр бэлтгэж байна.
16.	Дээврийн засвар хийх	Захирагчийн ажлын алба	2019.09.15	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа нийтийн зориулалттай орон сууцны дээврийн засварын ажилд хяналт тавьж ажилласан. Дархан сумын 9, 12, 13, 14 дүгээр багийн байрнуудын дээврийн засварын ажил бүрэн дуусаж улсын комисс ажилласан. 4 дүгээр баг 6 дугаар байр, Өргөө багийн 16 байрны дээврийн засварын ажил дууссан. 4 дүгээр багийн 5 дугаар байрны засварын ажил хийгдэж байна.
17.	Сумдын өвсний нөөцийн талаарх мэдээ тайлангуудад анхаарах	Хөрөнгө оруулалт, хөгжлийн	2019.09.15	ХХААГазарт 4 сумдын өвсний нөөцийн талаарх мэдээ, тайлан зөрүүтэй ирүүлсэн тул өвсний

	ХААГазраас ирж байгаа мэдээллүүд зөрөөд байна. Дээшээ яаманд бас ийм зөрүүтэй мэдээлэл өгч байна уу. Үүнд анхаарах хяналт тавьж ажиллах	бодлого, төлөвлөлтийн хэлтэс		нөөцийн тоо дүнг сумдуудтай тулгаж, сумдуудаас мэдээ авч үнэ зөв мэдээ ирүүлэх талаар чиглэл хүргүүлсэн.
18.	Сум, агентлагийн дарга нарыг ажил нь оруулах ээлжийн амралттай байгаа удирдлагуудыг дуудах	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	2019.09.15	2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар бүх сум, агентлагийн удирдлагуудаас ээлжийн амралттай байгаа удирдлагууд байхгүй байна.
19.	Шүүх өмгөөлөл, мэргэжлийн хяналтын газар, газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, татварын хэлтэс, СӨХ-үүд гэх мэт харьяа агентлагуудаас ТҮНТ-д ажиллахгүй байгаа цонхнуудыг ажиллуулахад анхаарах, үүрэг чиглэл өгөх	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	2019.09.15	ТЗУХэлтсээс холбогдох байгууллагуудад албан тоот хүргүүлсэн.
20.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд оруулах материалуудаа холбогдох бусад хэлтсүүдээс нэтгэн авч бэлтгэх	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	2019.09.15	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд хэлэлцүүлэх 1.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хэмжээг тогоох тухай 2.Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд газар авах тухай 3.Үйлдвэр технологийн паркийн аж үйлдвэрийн бүсэд өөрчлөлт оруулах тухай 4.Нийтийн тээврийн автобусны үнэ тарифт өөрчлөлт оруулах тухай 5.Уул уурхай, эрчим хүчний политехник коллежийг Рэнцэнгийн Лхагвасүрэнгийн нэрэмжит болгох тухай 6.Дархан сумын 28 дугаар цэцэрлэгийн үүсгэн байгуулагчийн төлөөлөл томилох тухай 7.Дархан хотын ерөнхий төлөвлөгөөний төсөл танилцуулах /2035 он хүртэлх/ 8.Дархан-Ус Суваг ХК-ийн Төлөөлөл Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 9.Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай /Дархан сумын 28 дугаар цэцэрлэг/ 10.Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай /Дархан-Ус Сувар ХК/ 11.Үндсэн хөрөнгө бүртгэх, зөвшөөрөл олгох тухай /Автомашин/ 12.Үндсэн хөрөнгө бүртгэх, зөвшөөрөл олгох тухай /Босоо заяатай Монгол/ 13.Үндсэн хөрөнгийг шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай /Орон сууц/зэрэг 13 асуудлын тараах

				материал болон танилцуулгыг цахим хэлбэрээр холбогдох хэлтсүүдээс авч 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн тоот албан бичгээр ИТХ-д хүргүүллээ.
--	--	--	--	--

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС